**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр Дугаар 131 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 150,458,040.00 (нэг зуун тавин сая дөрвөн зуун дөчин найман мянга дөчин) төгрөгийн балансын үнэ, 63,944,667.00 (жаран гурван сая есөн зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун жаран долоон) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлэн бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

000115

D:\Huraldaanii material\2020 on\2020.04.21 5r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 131 дугаар тогтоолын хавсралт

## Зам, тээврийн хөгжлийн яамаас Байгаль орчны яамны балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

| Д/д | Эд хөрөнгийн нэр | Үйлдвэрлэсэн/ Ашиглалтанд орсон огноо | Хэм жих нэгж | Тоо ширхэг | Балансын дүн (төгрөгөөр) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ланд крузейр-200 маркийн, УБЦ 20-89 улсын дугаартай, ёуудлын автомашин, арлын дугаар -JTMHX05J904063350 | 2014/2014 | ш | 1 | 150,458,040.00 | 63,944,667.00 | 86,513,373.00 |
| | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | | 1 (нэг) | **150,458,040.00** (нэг зуун тавин сая дөрвөн зуун дөчин найман мянга дөчин) | **63,944,667.00** (жаран гурван сая есөн зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун жаран долоон) | **86,513,373.00 (наян зургаан сая таван зуун арван гурван мянга гурван зуун далан гурван)** |